



ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН ТОГТООЛ

2022 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Гарын үсэг зурах эрх олгох тухай

Цөмийн энергийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5, Улсын Их Хурлын 2009 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого”-ын 3.1.5, 6.3, Засгийн газрын 2017 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Байгууллага хоорондын гэрээ байгуулах журам”-ын 1.3, Цөмийн энергийн комиссын дүрмийн 3.5, 4.1.2, 4.1.6, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 09/307 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Оросын Холбооны Улсын “Росатом” улсын корпорацитай Цөмийн шинжлэх ухаан, технологийн төв (ЦШУТТ)-ийг байгуулахад хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд “Русатом оверсиз” ХХК-тай байгуулах “ЦШУТТ байгуулах төсөл боловсруулах хэлэлцээр”-т гарын үсэг зурах эрхийг Монгол Улсын Их Сургууль (Б.Очирхуяг)-д олгосугай.

2. Хэлэлцээрийг байгуулсны дараа Байгууллага хоорондын гэрээ байгуулах журмын дагуу Гадаад харилцааны яаманд бүртгүүлэхийг Монгол Улсын Их Сургууль (Б.Очирхуяг)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилт, үр дүнг тайлагнахыг Монгол Улсын Их Сургууль (Б.Очирхуяг), тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цөмийн энергийн комиссын Ажлын алба (Г.Манлайжав)-нд тус тус даалгасугай.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД,
КОМИССЫН ДАРГА



Л.ЭНХ-АМГАЛАН